



МОНГОЛ УЛС  
ХОВД АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2019 оны 06 сарын 25 өдөр

Дугаар А/396

Ховд

Хөрөнгө гаргах тухай


Төсвийн тухай Монгол Улсын хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3 дахь заалт, 41 дүгээр зүйлийн 41.2.2 дахь заалт, Сангийн сайдын 2018 оны 318 дугаар тушаалаар баталсан “Засаг даргын нөөц хөрөнгийн зориулалт, зарцуулалтын нийтлэг журам”-ын 2.1.5 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь

1. Аймгийн Засаг даргын Жуух бичиг, Хүндэт өргөмжлөл захиалан хийлгэх зардалд 2 200 000 төгрөг, Бэлэг дурсгалын нөөцөд зохиолч Н.Сүхдоржийн “Өндөр хөхийн унага” роман худалдан авахад 800 000 төгрөг, Бэлэг дурсгалын зүйл худалдан авахад 680 000 төгрөгийг тус тус хавсралтаар баталж зарцуулсугай.

2. Дээрх арга хэмжээнүүдэд зарцуулах 3 680 000 төгрөг /Гурван сая зургаан зуун наян мянган/-ийг аймгийн Засаг даргын нөөц хөрөнгийн ангилагдаагүй зардлын нөөцөөс гаргахыг Засаг даргын Тамгын газрын дарга /Д.Энхболд/-д зөвшөөрсүгэй.

3. Захирамжийн хэрэгжилтэнд хяналт тавьж ажиллахыг Засаг даргын Тамгын газрын Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга /Ч.Багдал/-д үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА



Б.ДҮГЭРЖАВ

Zax A/396 Ch

02 01947

Аймгийн Засаг даргын 2019 оны 06 дугаар  
сарын 25 -ны өдрийн А/ 397 дугаар  
захирамжийн хавсралт

АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ЖУУХ БИЧИГ, ХҮНДЭТ  
ӨРГӨМЖЛӨЛ  
ЗАХИАЛАН ХИЙЛГЭХ ЗАРДЛЫН ТӨСӨВ

| Д.д | Зардлын төрөл, зүйл                     | ХНэгж | Тоо<br>ширхэг | Нэг бүрийн<br>үнэ<br>/төгрөг/ | Дүн /мян.төг/ |
|-----|---|-------|---------------|-------------------------------|---------------|
| 1   | Жуух бичиг                              | ш     | 80            | 12.000                        | 960.0         |
| 2   | Хүндэт өргөмжлөл                        | ш     | 120           | 10.300                        | 1 240.0       |
| 3   | "Өндөр хөхийн унага" роман              | ш     | 40            | 20.000                        | 800.0         |
| 4   | 8 тахилтай жаазтай сувинер<br>30см*85см | ш     | 8             | 85.000                        | 680.0         |
|     | НИЙТ ДҮН                                |       |               |                               | 3 680.0       |

-oOo-